АГУУЛГА


1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ............... 2

1.1 Төслийн товч мэдээлэл ........................................................................................ 2

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........................................................................................................ 3

2.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах ........................................... 3

2.2 Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах ............... 3

2.3 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийг бууруулах ........... 3

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ................................. 4

4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........................................................ 4

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........................................................ 4

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........................................................................................................ 4

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ................................... 5

8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ............. 5

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .................... 5

10. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ........................................................................................................ 6

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........................................................................................................ 6

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........................................................ 6

ДҮГНЭЛТ ........................................................................................................ 6

# 1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Төслийн товч мэдээлэл

“Сэкер ресорсус монголиа” ХХК нь Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт Хотгор нэртэй газарт MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021478 MV-021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай эзэмшдэг.

Засаг захиргааны хувьд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос баруун урагш ойролцоогоор 900км, Баянхонгор аймгийн төвөөс урагш 265км, Шинэжинст сумын төвөөс баруун хойш 7км зайд оршдог. Физик газарзүйн мужлалаар говийн их мужийн баруун мужид, Алтайн нурууны зүүн өмнөд талаар салбар Гичгэний нурууны зүүн урд үзүүрийн Саманд уулын хойд бэлд далайн төвшнөөс 2150метрийн өндөрт байрлана.

Тайлант онд уулын ажлын төлөвлөгөөгөөр уурхайн хилийн хүрээнд уулын явагдах бөгөөд хөрс хуулалт хийхгүй, зөвхөн орон нутгийн дулааны хэрэгцээнд зориулан 3000тн нүүрс олборлохоор төлөвлөсөн.

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийн бууруулах төлөвлөгөөний хүрээнд агаар орчныг хамгаалах, газрын хэвлий хөрс ургамлан бүрхэвчийг хамгаалах, усны чанар нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр 8 ажил төлөвлөсөн бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөнд өвөлжилтийн бэлтгэл хангах үеэр ажиллахаар тусгасан цаг хугацаатай уялдуудан ажиллаа.

### 2.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах

- Нүүрс олборлолт, тээвэрлэлтийн үед хүнд машин механизмын нөлөөгөөр тоосжилт үүсэх бөгөөд, нөлөөллийн бүсийн айл өрх, уухайн кемп орчимд агаар дахь тоосжилт нэмэгдэхээс сэргийлэн уурхай дотор болон уурхайн орох гарах хэсэгт замын хөдөлгөөний чиглүүлэх болон мэдээлэх тэмдэг хурд, хязгаарлах тэмдэг 17, 30-50м шороон хаалт хашилт хийсэн.
- Тайлант хугацаанд тоног төхөөрөмж, хүнд машин механизм ажиллаагүй бөгөөд орон нутгийн нүүрс олгох үед ажиллах тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүсэх хорт хийн агууламжид хяналт тавих, бууруулах арга хэмжээг гэрээт компаний тээврийн хэрэглсэл, хүнд машин механизмын техникийн бүрэн бүтэнд байдалд гэрээний дагуу хяналт тавин ажиллана.
- Нүүрсний агаарын бохирдлын төлбөр 11.3 сая төгрөг төлсөн.

### 2.2 Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах

- Шимт хөрсний овоолгыг тэмдэгжүүлж, үржил шимт байдлаа алдахаас сэргийлэн стандартад заасан өндрөөс хэтрүүлэлгүй овоолон хадгалж байна.

### 2.3 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийг бууруулах

- Уурхайн үйл ажиллагаанд нэмэлт тодотгол орсонтой холбогдуулан Баянхонгор аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраар ус ашиглах дүгнэлт гаргуулан, Шинэжинст сумын засаг даргын тамгын газарт ус ашиглах гэрээ байгуулах хүсэлт илгээсэн. Гэрээнд заасан дүнгээр ус ашигласны төлбөрийг төлж, гэрээний үүргээ биелүүлэн ажиллаа.
- Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Шинэжинст сумын сургуулийн сурагчдад танилцуулга мэдээлэл хүргэж, гар зургийн уралдаан зохио байгуулсан.
- Ундны усны чанар, аюулгүй байдлыг хангах, хяналт тавихаар холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, уурхайд зөөврөөр авч ашигладаг 2 дугаар багийн гүний худгийн ундны усыг MNS 0900 2018 стандартын дагуу шинжлүүлж, дүгнэлт гаргуулсан. Шинжилгээний дүгнэлтээр стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гараагүй.

### 2.4 Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах

- Ургамлан бүрхэвч бохирдох, хөрсний өнгөн давхарга элэгдэж эвдрэхээс сэргийлж байгаль хамгаалах төлөвлөгөөний дагуу замын хөдөлгөөний тэмдэг байрлуулах, салаа замуудыг хаах арга хэмжээ авсан.

## 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тайлант онд үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр нүүрс олборлолтыг зөвхөн III давхаргын 8В блокоос орон нутгийн дулааны хэрэгцээнд 3.0 мян.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн бөгөөд гадаад дотоод овоолгоор хийх техникийн нөхөн сэргээлт төлөвлөөгүй.

## 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тэр бум мод хөтөлбөр хэрэгжүүлэх: 2022 онд тоосжилт, дуу чимээг бууруулах болон салхинаас хамгаалах салхины хурд саар зорилгоор сумын баруун хойд зүгт 1,2га талбайг хашаалж, хамгаалалтын зурвас байгуулсан. Тус талбайн нөхөн тарилтаар 2023 оны 5 дугаар сард хайлаас-500ш, бургас-200ш, шар хуайс-200, үрхийн нүд-30ш, голт бор-20ш, улиас-50ш нийт 1000ш 2-3 настай суулгац тарьсан. Тарьц суулгацын амьдралтын хувийг тооцохдоо ургал эрхтэн хатаж, үхсэн суулгацын тоог бүртгэж дараах томъёогоор тодорхойлах ба дараа жилийн тооллогыг ургамал ургалтын хугацаанд гүйцэтгэж, нөхөн тарилт хийх модны тооцоог гаргана.

$$SR(\%) = \frac{TNS - NDS}{TNS} * 100$$

SR /survival rate/- амьдралтын хувь

TNS /total numberof seedlings/- нийт суулгацын тоо

NDS /number of dead seedlings/- үхсэн суулгацын тоо

## 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хотгорын уурхайн MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021478 MV-021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай болон нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох айл өрх байхгүй тул энэ ажил төлөвлөгдөөгүй.

## 6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Түүх соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчилах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, холбогдох харилцааг зохицуулах зорилттой Соёлийн өвийн тухай хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлж 2011-2014 онуудад ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран археологийн хайгуул судалгаа, археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажил хийсэн.

Тус хээрийн судалгаагаар нийт 25 дурсгал олдсоноос хадны зургийн дурсгал 5, булш оршуулгын дурсгал 12, чулуун байгууламж 4, тахилгат овоо 3, төв бичигтэй хөшөө 1 тус тус олдсон.

Төслийн ажилтнууд, гэрээт байгууллагын ажилтнуудад Орон нутгийн харилцаа болон Соёлын өвийн олдвор, дурсгалт зүйлс олдох үед мэдээлэл хадгалах аргазүйн зааварчилгаа өгч ажиллаа.

## 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### Гал түймрээс урьдчилан сэргийлэх

- Уурхайн ажилчдын суурин дахь галын аюулд өртөж болзошгүй объектуудад гал унтраагуур, галын сараа байрлуулж гал унтраагуурын бүрэн бүтэн байдал хэвийн ажиллагааг шалгаж, үзлэгийн хуудаст тэмдэглэсэн. Жилийн эцсийн тооллогоор уурхайн кемпэд нийт 5 галын хор, 2галын сараа байрлуулсан.

### Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах

- ХАБЭА-н сургалт: 6 дугаар сард Нийт ажилтнууд болон гэрээт компанийн ажилтнуудад ХАБЭА-н батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу ХАБЭА-н журам, зааварчилаag танилцуулах сургалт зохион байгуулсан.
- Өдөр тутмын зааварчилгаа: Олборлолтын үед ажиллах гэрээт компаний ажилчдад өдөр тутмын зааварчилгааг уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан өгч, аюулгүй байдлыг хангаж ажиллаа.

## 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 8.1. Ахуйн хог хаягдал

Сумын засаг даргатай хог хаягдлын гэрээ байгуулж, төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулсан. Хог хаягдлын тухай хуулийн дагуу “Жинст цохио” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан уурхайн үйл ажиллагаанаас үүсэх энгийн хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн битүүмжлэл сайтай ангилан ялгах 1тн багтаамж бүхий стандартын шаардлагад нийцсэн хогийн сав байрлуулсан. Үйл ажиллагаа хэвийн явагдаж эхлэх үед энийг хог хаягдлын бүртгэл хөтөлж, дахин ашиглах хуванцар хаягдлыг дахивар авах цэгт нийлүүлнэ.

### 8.2. Аюултай хог хаягдал

- "Цэвэр хот" ОНӨААТҮГ-тай аюултай хог хаягдал зайлуулах гэрээ байгуулсан. Уурхайн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхлэх үед бүртгэл хөтөлж журамд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

## 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Баянхонгор аймгийн УЦУОШТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж, тайлант оны хөрс ус агаарын хяналт шинжилгээг хийлгэсэн.

### 9.1. Хөрсний шинжилгээ

- БОННҮ-д заасан 3 цэгээс дээж авч шинжлүүлэн дүгнэлт гаргуулсан.
- Шимт хөрсний ялзмаг, механик бүрэлдэхүүн, биохимийн шинжилгээ хийлгэсэн.

### 9.2. Агаарын чанарын шинжилгээ

- Уурхайн 3 цэгт агаарын чанарын хэмжилт хийж, шинжилгээний дүнг харьцуулан дүгнэлт гарсан.

### 9.3. Усны чанарын хяналт шинжилгээ

- Усны шинжилгээний хариуг хавсаргав.

## 10. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайн байгаль орчны асуудлаар 2023 онд Баянхонгор аймгийн Засаг даргаас шаардлага ирүүлээгүй болно.

## 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- Дэлхийн усны өдрийн тохиолдуулан Шинэжинст сумын ЕБС-ийн ангийн дунд ангийн сурагчдыг хамруулан “Усаа хайрлая” гар зургийн уралдаан зохион байгуулж, амжилттай оролцсон сурагчдад мөнгөн шагнал дурсгалын зүйлс гардуулсан.
- Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг дор зохион байгуулагддаг “Мод тарих үндэсний өдөр”-р Шинэ жинст сумын иргэдийн төлөөлөл болон ЕБС-ийн сургуулийн сурагчдыг оролцуулан сумын ойролцоо Цагаан худгийн модны талбайд 100 мод тарьсан.
- Ахуйн шингэн хаягдлыг орчны бохирдол үүсгэхээргүй хүчитгэсэн доторлоготой, дахин ашиглах шаардлага хангасан хийц бүхий нэвчилтгүй нийтийн бие засах газар байгуулахаар төлөвлөж, Шинэжинст сумын ЗДТГ-т хаягдал усны цэг тогтоолгох албан хүсэлт хүргүүлсэн.

## 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- Байгаль орчныг хамгаалах талаар хэрэгжүүлсэн ажлыг сумын байгаль хамгаалах улсын байцаагчтай хамтран ажиллаж, тайланг тухай бүрд сумын засаг даргад танилцуулсан.

## ДҮГНЭЛТ

1. “Сэкер ресорсус монголиа” ХХК нь тайлант онд байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга ажиллагааг зохион байгуулах, хариуцлагатай уул уурхай эрхлэх, байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулахаар 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг  батлуулсан. Нийт төсөв 15,5 сая төгрөг.
2. Тайлант онд байгаль хамгаалах чиглэлээр ... төгрөг, Нийгмийн хариуцлагын хүрээнд сум орон нутагт ... төгрөгийн хандив тусламж, ... төгрөгийн татвар хураамж, (сумын төсөвт .... төгрөг, аймгийн төсөвт .... төгрөг) улсын төсөвт ... төгрөгийн татвар хураамж төлсөн.

3. Тайлант онд тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй хэдий ч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэхийг зорьж, нутгийн удирдлагын байгууллагатай хамтарч ажиллаа.
4. Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн иргэдийн өвөлжилтийн бэлтгэл хангахад 4 багийн 750 гаруй өрхөд 1тн нүүрс үнэгүй олгож сум орон нутгийн иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэн ажиллаа.

Хавсралт

















1 of 1

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

## НЭХЭМЖЛЭХ

ДДТД: 000003142175000231005000001087580
**Нэхэмжлэгч:**
ТТД: 3142175
НЭР: Түйн голын төгөл
Хаяг: Монгол, Баянхонгор, Баянхонгор, 6-р баг, Гэгээн шавь, Баянхонгор Баянхонгор 6-р баг, Гэгээн шавь null, Мод ургуулах 1 тоот, Мод ургуулах 1 тоот
Утас: 88066844
Э-Шуудан: undefined
Банкны нэр: Голомт банк
Банкны дансны дугаар: 6105124140

**Хариуцагч:**
ТТД: 2862468
Нэр: Сэкер ресорсус монголиа
Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, , Корпорэйт зочид буудал энд конвеншн центр 6 давхар
Утас: 99113063
Гэрээний №:
Огноо: 2023-10-04
Төлбөр хийх хугацаа(Хоног):

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил | 435 | ш | 1000 | 8,000 | 8,000,000 |
| | | | | | Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 8,000,000 |
| | | | | | Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 0 |
| | | | | | Нийслэл хотын албан татвар: | 0 |
| | | | | | Нийт дүн: | 8,000,000 |

Мөнгөн дүн: ..........................................................
(үсгээр)
..........................................................болно

(Тамга) Захирал:................/................/
Нягтлан бодогч:................/................/

ARIMT.MN

## НЭХЭМЖЛЭХ

ДТД: 000003142175000231014000001580159
эхэмжлэгч:
ТД: 3142175
ЭР: ТҮЙН ГОЛЫН ТӨГӨЛ
аяг: Монгол, Баянхонгор, Баянхонгор, 6-р баг, Гэгээн шавь, Баянхонгор Баянхонгор 6-р баг, Гэгээн шавь null, Мод ургуулах 1 тоот, Мод ургуулах 1 тоот
Утас: 88066844
Э-Шуудан:
Банкны нэр: Голомт банк
Банкны дансны дугаар: 6105124140

**Хариуцагч:**
ТТД: 2862468
НЭР: СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА
Хаяг: Монгол, Улаанбаатар, Хан-Уул, 15-р хороо, , Корпорэйт зочид буудал энд конвеншн центр 6 давхар
Утас: 99113063
Гэрээний №: ......
Огноо: 2023-10-14
Төлбөр хийх хугацаа(Хоног): ......

| Д/д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил | 435 | ш | 100 | 3,000.00 | 300,000.00 |
| | | | | | Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 300,000.00 |
| | | | | | Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 0.00 |
| | | | | | Нийслэл хотын албан татвар: | 0.00 |
| | | | | | Нийт дүн: | 300,000.00 |

Мөнгөн дүн: ..........................................................
(үсгээр)
..........................................................болно

(Тамга) Захирал:................/................/
Нягтлан бодогч:................/................/

Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний хүрээнд мод тарив.





Дэлхийн усын өдрийг тохиолдуулан гар зургийн уралдаан зохион байгуулав.

Тайлангийн хавсралтууд:

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны бүрдэл хэсгүүд тус бүр дээр хэмжилт, дээжлэлт хийж буй агшныг баталгаажуулсан, төсөл хэрэгжиж буй орчны фонтой хамт авсан гэрэл зураг /цэг бүр дээр 2-оос доошгүй/
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн хээрийн хэмжилт, авсан дээжнүүдийн лабораторийн шинжилгээний үр дүн эх хувиар
- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг баталгаажуулсан гэрэл зураг /арга хэмжээ бүрт 2-оос доошгүй орчны фонтой хамт авсан гэрэл зураг хавсаргах/
- Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг харуулсан гэрэл зураг /нэгж талбай бүр дээр хийхээс өмнө, хийж байх үеийн, хийсний дараах байдлыг харуулсан гэрэл зургууд хавсаргах/, нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн ажлын зардлын нотлох баримтууд
- Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ /арга хэмжээ бүрт орчны фонтой хамт авсан 2-оос доошгүй гэрэл зураг хавсаргах/
- Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн зарцуулсан химийн хортой болон аюултай бодисын ашиглалтын дүн мэдээ
- Аюултай хог хаягдлыг устгах, хадгалах арга хэмжээг хэрхэн гүйцэтгэснийг нотлох гэрэл зураг /арга хэмжээ бүрт орчны фонтой хамт авсан 2-оос доошгүй гэрэл зураг хавсаргах/
- Эрх бүхий байгууллагуудаас гүйцэтгэсэн ажлыг нь хүлээж авсан актын хуулбар
- Хуваарьт болон хуваарьт бус аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан
- БОХ-3 маягт. Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн жилийн мэдээ
- Хайгуулын ажил, ТЭЗҮ-г хүлээн авсан тушаал, тэмдэглэл
- БОМТ-ний биелэлтийн тайлан хүлээн авах хяналтын хуудас
- Байгууллагын хариуцлагын даатгалын хуулбар
- Нөөц ашигласны төлбөр тушаасан баримтын хуулбар
- Нөөцийн хөдөлгөөний тайлангийн хуулбар
- Хилээр экспортод гаргасан бүтээгдэхүүний талаар гаалийн албанаас гаргасан мэдээ

**БАТАЛСАН:**

“СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА” ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

_______________/М.ЧОЙДОРЖ/

**ТАНИЛЦСАН:**

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА

_______________/Л.БАЯРМАНДАЛ/

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН НУТАГТ ОРШИХ ХОТГОР ЧУЛУУН НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ (тодотгол-I)

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021487, MV-021488

*Хүчин чадал: 8.0 сая.тн/жил*

**ХЯНАСАН:**

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН САЛБАР

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ХУЛАН

**ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ:**

МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР Ц.ОЮУНБААТАР

**ТӨСЛИЙН ШИНЖЭЭЧ:**

МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР Х.ЖАРГАЛСАЙХАН

МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР Б.БАТ-УЯА

Улаанбаатар хот

2022 он

**ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАГЧ:**

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ЗУРАГ ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ

"ГЛОЖЕКС КОНСАЛТИНГ" ХХК /Э.САМБУУДОРЖ/ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

| Ажил үүрэг | Овог нэр | Мэргэжил, албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|
| Төслийн удирдагч | Н.Буян-Өлзий | Төслийн удирдагч | |
| Ил уурхайн зураглал, технологийн паспорт зураг | Ч.Энхжаргал | Уулын мэргэшсэн инженер | |
| Ил уурхайн төлөвлөлт | Б.Дамдинбаяр | Төлөвлөлтийн инженер | |
| Ил уурхайн зураглал, технологийн паспорт зураг, нөхөн сэргээлтийн төлөвлөлт | У.Болд-Эрдэнэ | Уулын инженер | |
| Баяжуулах үйлдвэрийн технологийн зураг, технологийн нэгтгэсэн тооцоо | Ч.Отгонцэцэг | Баяжуулагч инженер | |
| Баяжуулах үйлдвэрийн технологийн зураг, технологийн нэгтгэсэн тооцоо | Н.Баасансүрэн | Баяжуулагч инженер | |
| Төслийн дэд бүтцийн бүлэг, тооцоолол | Д.Батболд | Дэд бүтцийн инженер | |
| Зах зээлийн судалгаа, хүний нөөцийн төлөвлөлт | Б.Отгончимэг | Эдийн засагч | |
| Төслийн үнэлгээ, эдийн засгийн тооцоо, тооцооны нэгтгэл | Э.Самбуудорж | Эрдэс баялгийн эдийн засагч | |

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

**ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН**

# ДҮГНЭЛТ

2022 оны 11 дугаар сарын 25 №1/22-11-02 Улаанбаатар хот

*Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021487, MV-021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Хотгор" нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-I-ийг хэлэлцсэн тухай*

Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн Гложекс консалтинг ХХК-ийн боловсруулсан Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших "Хотгор" нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-I-д Уул уурхайн зөвлөх инженер Ц.Оюунбаатар зөвлөж, Уул уурхайн зөвлөх инженер Х.Жаргалсайхан, Уул уурхайн мэргэшсэн инженер Б.Бат-Уяа нар шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол- I-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэл нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

2. Техник, эдийн засгийн үндэслэл нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, баяжуулах үйлдвэрийг эхлэн байгуулж, үйлдвэрлэл явуулах бүх шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

3. Техник, эдийн засгийн үндэслэл нь Төслийн танилцуулга, Төслийн талбайн ерөнхий мэдээлэл, Геологийн судалгааны түүх, геологийн тогтоц, Ил уурхайн



53781013

төлөвлөлт, Нүүрс угаан баяжуулах үйлдвэр, Уурхайн дэд бүтэц, Ажиллах хүчний төлөвлөлт ба олон нийтийн харилцаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчин, уурхайн хаалт, Зах зээлийн судалгаа, Эдийн засаг гэсэн 11 бүлэг, дүгнэлт, хавсралт материал бүхий 260 хуудас тайлбар бичиг, 35 хавсралт зургуудаас бүрдэж байна.

4. “Хотгор” нэртэй чулуун нүүрсний ордын MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021487, MV-021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2011 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны XX-17-01 тоот дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмалын газрын даргын 2012 оны 02 сарын 16-ны өдрийн 94 тоот тушаал, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны XX-13-07 тоот дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2019 оны 09 сарын 16-ны өдрийн н/112 тоот тушаалаар нийт бодитой ба боломжтой (B+C) зэрэглэлээр 171.04 сая.тн үүнээс бодитой (B) зэрэглэлээр 124.58 сая.тн, боломжтой (C) зэрэглэлээр 46.46 сая.тн чулуун нүүрсний нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэжээ.

5. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн хаягдал 1.87% буюу 1.97 сая.тн, бохирдлыг 1.43% буюу 1.48 сая.тн авч тооцсоноор, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн нийт бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 105.11 сая.тн үүнээс бодитой (B) зэрэглэлээр 93.48 сая.тн, боломжтой (C) зэрэглэлээр 11.62 сая.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн байна. Уурхайн хүчин чадлыг ашиглалтын 1-р жилд 200.0 мянган тонн, 2-р жилд 1.4 сая тонн, 3-р жилд 6.0 сая тонн, 4-р жилээс эхлэн төслийн хүчин чадал 8 сая тонн/жилд хүргэхээр төлөвлөж, нийт 15 жил ашиглахаар төлөвлөжээ.

6. “Хотгор” нэртэй чулуун нүүрсний ордын уул-геологийн нөхцөл, нүүрс олборлолт болон хөрс хуулалтын хэмжээ зэргээс хамааруулан авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

7. Ил уурхайд өрөмдлөг тэсэлгээний ажилд SandvikD45KS (152-229мм) маркийн өрмийн машин 3 ширхэг, SANY (138-180мм) маркийн өрмийн машин 1 ширхэг, хөрс хуулалтад 34м$^3$ утгуурын багтаамжтай CAT6060FS маркийн экскаватор 4 ширхэг, нүүрс олборлолтод 10м$^3$ утгуурын багтаамжтай CAT6018FS маркийн экскаватор 2 ширхэг, хөрс тээвэрлэлтийн ажилд 240 тонны даацтай CAT793D 40 ширхэг, нүүрс тээвэрлэлтэд 64 тонны даацтай CAT775G маркийн автосамосвал 30 ширхэг, 8.7 м$^3$ багтаамжтай CAT988K маркийн дугуйт ачигт 5 ширхэг, CATD8R маркийн бульдозер 6 ширхэг зэрэг тоног төхөөрөмжүүдийг үндсэн процессуудад ашиглахаар сонгон тооцоолжээ.

8. Нүүрс угаан баяжуулах үйлдвэр нь орд ашиглалтын 3 дах жилээс нийт 13 жилийн хугацаанд ажиллах ба жилийн хүчин чадал нь 8.0 сая тонн бөгөөд тус бүр 4.0 сая тонн хүчин чадалтай 2 модуль байхаар төлөвлөжээ. Австрали улсын “A&B MYLEC Pty. LTD технологийн судалгааны төвд 2019 онд гүйцэтгэсэн нүүрс шигшүүрийн шинжилгээ, фракцын шинжилгээ, баяжигдах чанарын шинжилгээ зэрэг туршилт судалгааны ажил хийгдсэн бөгөөд уг туршилтаар нүүрс нь хөнгөн баяжигдах шинж чанартайг тодорхойлсон байна. Баяжуулах үйлдвэр нь 23.6% үнслэгтэй түүхий

нүүрсийг гравитац болон флотацын аргаар баяжуулснаар 77.8%-ийн гарцтай 76.9 сая тонн хагас зөөлөн коксжих нүүрс, 5.17%-ийн гарцтай 5.1 сая тонн завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөжээ.

9. Төсөлд нийт 11.2 мегаваттын эрчим хүч шаардлагатай бөгөөд өөрийн 18 мегаваттын хүчин чадалтай цахилгаан станц барьж байгуулан шийдвэрлэхээр тусгасан байна. Уурхайн технологийн усны хэрэгцээнд жилд дунджаар 58 мян.$м^3$, баяжуулах үйлдвэрийн хэрэгцээнд 1,569 мян.$м^3$, бусад хэрэгцээнд жилд 24 мян.$м^3$ ус хэрэглэхээр төлөвлөн ба төсөлд нийт 76 л/сек-ийн усны ундаргатай эс үүсгэвэр шаардлагатай бөгөөд Ар Пи Эс Акватерра ХХК-ийн гүйцэтгэсэн усны эрэл хайгуулын ажлын үр дүнгийн дагуу шүүрлийн ус болон гүний худгаас хангахаар тооцоолжээ.

10. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 36.1 тэрбум төгрөг зарцуулахаар тооцоолсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 3.5 тэрбум төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 17.4 тэрбум төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 9.3 тэрбум төгрөг, мониторингийн зардалд 1.7 тэрбум төгрөг, дүйцүүлэн хамгаалах зардалд 1.2 тэрбум төгрөг, бусад ажилд 3.0 тэрбум төгрөг тус тус зарцуулахаар төсөлд тусгажээ.

11. Уг төслийг хэрэгжүүлснээр 1,116 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 2,49 мян.төг байхаар байна.

12. Төсөл хэрэгжүүлэхэд нийт 1,228.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс бэлтгэл ажлын хөрөнгө оруулалт 0.8 тэрбум төгрөг, баяжуулах үйлдвэрийн үндсэн техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 417.7 тэрбум төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 758.9 тэрбум төгрөг, хотхонд 37.1 тэрбум төгрөг, төв оффис 3.6 тэрбум төгрөг, хайгуулын ажлын зардал 4.4 тэрбум төгрөг, биет бус хөрөнгө оруулалтад 5.8 тэрбум төгрөг тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардалд жилд дунджаар 72.8 тэрбум төгрөг байхаар тооцоолсон байна.

13. Уурхайг ашиглах хугацаанд нийт 19,183.5 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 26,246.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 7,062.6 тэрбум төгрөгийн татварын өмнөх, татвар ногдуулсны дараах байдлаар нийт 5,271.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 4,053.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд нэгж баяжуулсан бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөг 249.4 мян.төг/тн байна.

14. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 6,363.4 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @10%) 1,730.5 тэрбум төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 31%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 4.7 жил байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник, эдийн засгийн үндэслэлийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна. Үүнд:

1. Цаашид үйл ажиллагаа явуулахдаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг жишиг үнээс төлж байх;

2. Төсөл захиалагч нь Уул уурхайн сайд, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 229/А232 тоот хамтарсан тушаалаар батлагдсан Хүдрийн ил болон далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулах;

3. Төсөл захиалагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн, уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийх;

4. Төсөл захиалагч нь шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах;

5. Засгийн газрын 379-р тогтоолоор батлагдсан “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид анхааруулж байна.

6. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, баяжуулах үйлдвэр, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн Гложекс консалтинг ХХК, мөн техник, эдийн засгийн үндэслэлийн үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Уул уурхайн зөвлөх инженер Х.Жаргалсайхан, Уул уурхайн мэргэшсэн инженер Б.Бат-Уяа нар тус тус хариуцах;

ТУС & 0810

Техник, эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021487, MV-021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хотгор” нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-I-ийг хүлээн авах;

2. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэйг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;

3. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших MV-012728, MV-017057, MV-017060, MV-017061, MV-017062, MV-021487, MV-021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хотгор” нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-I, түүнийг хуулсан диск, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ХУРАЛДААНЫ ДАРГА Ч.ЦОГТБААТАР

ТУС Я 0810

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.ХУЛАН

# АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 14 өдөр          Дугаар Т/18          Улаанбаатар хот

Техник, эдийн засгийн үндэслэл
бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Т/22-11-02 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн MV-012728, MV-017057, MV-017060, MV017061, MV-017062, MV-021487, MV021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй “Хотгор” нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-I-ийг бүртгэсүгэй.

2. Бүртгэсэн техник, эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, геологийн нөөцөөс хөдөлгөөн хийхийг Уул уурхайн хэлтэс (М.Мэндбаяр)-т даалгасугай.

3. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу явуулахад хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн хэлтэс (М.Мэндбаяр)-т даалгасугай.

4. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан төслийн хүчин чадал, техник, технологид өөрчлөлт орсон, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн хэлтэс (М.Мэндбаяр)-т даалгасугай.

5. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Сэкер Ресорсус Монголиа ХХК-ийн MV-012728, MV-017057, MV-017060, MV017061, MV-017062, MV-021487, MV021488 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй “Хотгор” нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-I-ийг хуулсан дискийг төсөл эзэмшигчээс хүлээн авахыг Уул уурхайн хэлтэс (М.Мэндбаяр)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ          Л.БАЯРМАНДАЛ

53710183

**SAKER RESOURCE MONGOLIA LLC**
**CONTRACT HANDOVER PAGE/**
**ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ХУУДАС**

Original to be kept by/Эхийг хадгалах: Legal Division/Хуулийн хэлтэс
Issue Date/Гаргасан огноо: 2023.04.18
Pages/Хуудас: 1

***Гэрээний товч утга:*** Энэхүү Гэрээгээр Гүйцэтгэгч нь захиалагчид гэрээний хавсралтад дурдсан бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, шинжилгээ хийсний үндсэн дээр дүгнэлт мэдээлэл өгөх ажил байна.

***Нийт үнэ:*** 1,422,800 төгрөг (НӨАТ орсон дүн)

***Гэрээний хугацаа:*** 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл

***Гэрээний байгуулах хүсэлтийг хариуцсан албан тушаалын тодорхойлолт, компанийн ажлын төлөвлөгөөнд заасны дагуу ирүүлсэн, цаашид гэрээний хэрэгжилтийг хариуцаж ажиллах ажилтан:***

Байгаль орчин хариуцсан ажилтан: Б.Дэлгэрэх . Б.Дэлгэрэх

***Гэрээний төслийг бэлтгэсэн:*** Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын стандарт гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар бэлтгэв.

Туслах хуульч: Б.Буянтогтох Б.Буянтогтох

The undersigned confirms that the draft contract has been reviewed and approved the final version of the contract. (Contract No. ............. /2023) 2023 02010017
Дор гарын үсэг зурсан нь 2023 оны ...................... дугаар Гэрээний төслийг хянаж, гэрээний эцсийн хувилбарыг зөвшөөрч байна.

| Contract title/Гэрээний нэр: | **БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН АГААР, УС, ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ГЭРЭЭ (Баянхонгор аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв)** | | | | |
|---|---|---|---|---|---|
| Renewed by /Хянасан: | Divisions/ Газар, хэлтэс | Name/Овог, нэр | Comment/Санал | Date/ Огноо | Sign/Гарын үсэг |
| Saker Resource Mongolia LLC | Ерөнхий захирал | М.ЧОЙДОРЖ | | [signature] | |
| Saker Resource Mongolia LLC | Үйл ажиллагаа хариуцсан захирал | М.БАЯРМАНЛА | Нэмэлт санал үгүй | 2023.04.27 | М.Б |
| Saker Resource Mongolia LLC | Санхүү, хөрөнгө оруулалт, төслийн хэлтсийн ерөнхий менежер | Б.МӨРӨНГУА | Зөвшөөрсөн | 2023/04/20 | Б.Мөрөнгуа |

N.B.: If the person is on the site or on a business trip then confirmation should be obtained via e-mail and should be attached to the confirmation page. In the case of absence of signatory due to illness or other private reasons the acting officer shall sign on the confirmation page.
After all approvals, contract could be approved by Executive Director.
Анхаарах нь: Хэрэв тухайн хүн орон нутаг дахь ажлын байранд, эсхүл томилолтой байгаа бол зөвшөөрлийг цахим шуудангаар авч хяналтын хуудаст хавсаргана. Гарын үсэг зурагч нь өвчний, эсхүл хувийн бусад шалтгаанаар эзгүй байгаа тохиолдолд үүргийг орлон гүйцэтгэж буй ажилтан хяналтын хуудаст гарын үсэг зурна. Бүх зөвшөөрлийг авсны дараа Гүйцэтгэх захирлаар гарын үсэг зуруулна.

| | |
|---|---|
| БАТЛАВ.<br>УС, ЦАГ УУР, ОРЧНЫ<br>ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА<br>.......................... (Ч.ОЮУНЧИМЭГ)<br>2023 оны 05 сарын 12 -ний/ны өдөр | БАТЛАВ.<br>"СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА"<br>ХХК-Н ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ<br>.......................... (М.ЧОЙДОРЖ)<br>2023 оны 05 сарын ....... -ний/ны өдөр |

# БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН АГААР, УС, ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ГЭРЭЭ

20230201001?

## НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1 Үйлдвэр, албан байгууллага, шатахуун түгээх станц, аж ахуйн нэгжийн болон хувийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээнд, байгаль орчинд гарч болох хими, физик, биологийн хувьсал өөрчлөлт агаар, ус, хөрсний бохирдлын түвшинд байгаль орчны ажиглалт, тандалт судалгаа, бохирдлын хяналт шинжилгээ хийнэ.

1.2 Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын уурхайн эзэмшлийн талбайд орчны хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэхэд оршино.

1.3 "Сэкер Ресорсус Монголиа" ХХК-ийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тогтоох, болзошгүй ослоос сэргийлэх зорилгоор агаар, ус, хөрсний бохирдолтод хяналт тавих орчны шинжилгээний ажлыг гүйцэтгэхэд, үүсэх харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХАРИЛЦАГЧ ТАЛУУД

2.1 Нэг талаас "**СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА**" ХХК (РД:2862468) (цаашид "Захиалагч" гэх) нөгөө талаас Баянхонгор аймгийн **УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ** (цаашид "Гүйцэтгэгч" гэх) зэрэг байгууллагууд нь энэхүү гэрээний харилцагч талууд болж гэрээний биелэлтийг бүрэн хариуцаж, хамтран ажиллана.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан ба ерөнхий үнэлгээнд заасан шинжилгээний ажлын дагуу шаардлагатай үед агаар, ус, хөрсөнд байгаль орчны хяналт шинжилгээ хийх;

3.2 Лабораторийн шинжилгээний ажлыг Монгол улсад мөрдөгдөж байгаа стандарт, арга аргачлалын дагуу заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэх;

3.3 Захиалагчаас нийлүүлсэн шинжилгээний сорьц (дээж)-ыг шалгаж хүлээн авах, чанарыг алдагдуулахгүйгээр шинжилгээнд оруулах;

3.4 Байгаль орчны хяналт шинжилгээ хийх багаж тоног төхөөрөмж, шаардагдах урвалж бодис уусмалаар хангагдсан байх;

3.5 Шинжилгээний дүнд ямар нэгэн буруу, эргэлзээтэй, дутуу зүйл гарвал түүнийг засах, давтан шинжилгээ хийх асуудлыг хариуцах;

3.6 Гэрээт ажлын төлбөрийг барагдуулахыг шаардах, нэхэмжлэх;

3.7 Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад хүндэтгэх шалтгаанаар хүндрэл учирсан тохиолдолд захиалагч талд нэн даруй мэдэгдэж зохих арга хэмжээ авах;

3.8 Гүйцэтгэгч нь Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасны дагуу ажилтнуудынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг шууд хариуцна. Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн стандарт, дүрэм, заавар, технологийн горимын мөрдөлтөд дотоодын хяналтыг тавьж, ажилтнуудынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг бүрэн хангаж, удирдан ажиллах үүргийг хүлээх;

3.9 Гүйцэтгэгч нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль, дүрэм, журмуудыг зөрчсөнөөс үүдэн өөрийн ажилтан болоод бусад этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан бол бие даан хариуцах ба маргаанаас Захиалагч талыг ангид байлгаж, хохирол болон бусад асуудлыг өөрөө бүрэн хариуцах;

3.10 Гүйцэтгэгч нь Хотгорын уурхайд гэрээт ажлыг гүйцэтгэх үед гарсан хог хаягдлыг хууль тогтоомж, дүрэм журам, стандартад заасны дагуу ангилан ялгаж цуглуулах бөгөөд Баянхонгор аймгийн Баянхонгор суманд зөөвөрлөн авчирч, хог хаягдал цуглуулах эрх бүхий газарт хаяна. Мөн уурхайн талбайд асгарсан тос масло, хог хаягдалд үүсгэхгүй байх;

3.11 Гүйцэтгэгч нь энэ Гэрээний 3.1-т заасан шинжилгээ хийж буй үйл явцыг болон энэ Гэрээний 3.10-т заасан ажлыг гүйцэтгэж байгаагаа нотолсон баримт, гэрэл зургийг авч Захиалагч талд хүлээлгэн өгнө.

## ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Байгаль орчны хяналт шинжилгээний тухай хуулийг чанд мөрдөн ажиллах;

4.2 Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын зардлыг БОАЖЯ-наас тогтоосон тарифт үнэлгээний дагуу төлөх;

4.3 Байгаль орчны хяналт шинжилгээг тогтоосон хугацаанд тогтмол хийлгэх;

4.4 Байгаль орчны хяналт шинжилгээний сорьц (дээж) авах боломжийг хангах;

4.5 Шинжилгээний дүн, дүгнэлтээр илэрсэн зөрчлийг тухай бүр нь арилгах, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх;

4.6 Хяналт шинжилгээний зардал, тээврийн (унааны) болон тухайн ажилтны томилолтыг “Сэкер Ресорсус Монголиа” ХХК бүрэн хариуцаж шинжилгээг хийлгэх;

4.7 Шинжилгээний төлбөрийг 3 хоногийн дотор бэлэн болон бэлэн бусаар төлнө.

## ТАВ. ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛБӨР ТООЦОО

5.1 Агаар, хөрсний чанарын хяналт шинжилгээний дээж (сорьц)-ийг тухайн заасан цэгүүдээс авч химийн бохирдлын (задлан) шинжилгээг хийнэ.

5.2 Усны чанарын хяналт шинжилгээний дээж (сорьц)-ийг тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа уст цэг (цэвэр,бохир) тус бүрээс авч задлан шинжилгээг хийнэ.

5.3 Захиалагч тал гэрээт ажлын зардлыг ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгч талын нэхэмжлэхийг үндэслэн Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн Төрийн сангийн 100030013015 тоот дансанд (РД:9007539) шилжүүлнэ. Төлбөр төлсөн баримтын нэг хувийг шинжилгээний үр дүнг хүлээн авахдаа авчирч тооцоо хийнэ.

## ЗУРГАА. ЯВАХ МАРШРУТ, ШАТАХУУН ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО, АЖИЛЛАХ ХУГАЦАА

6.1 Ажиллах хугацаа: 2023 оны ... -р сарын ...-ний/ны өдрөөс 2023 оны ...-р сарын ...-ний/ны өдрүүдэд ажиллана.

| *д/д* | *Багийн нэр* | *Сум хооронд км* | *Зарцуулах бензин, масло* | *Нийт шатахууны зарцуулалт* |
|---|---|---|---|---|
| *1* | *2* | *3* | *4* | *5* |
| *чиглэл* | Баянхонгор-Шинэжинст | *280* | *60* | *151800* |
| | Шинэжинст- Баянхонгор | 280 | 60 | 156000 |
| | Нийт шатахууны зардал=307800+22000(Масло)=329800 | | | |
| Нийт шатахууны зардал=329800*2=659600+22000=681600 | | | | |

Жич:Орон нутагт шатахууны үнийг 2600 төгрөгөөр тооцсон болно.

## ДОЛОО. ХАМТРАН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

7.1 Шаардлагатай гэж үзвэл хоёр тал харилцан тохиролцож гэрээнд өөрчлөлт оруулж болно.

7.2 Гэрээний холбогдолтой маргааныг хоёр тал тохиролцож үл чадваас хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

7.3 Гэрээний биелэлтэд хоёр тал харилцан хяналт тавьж, гэрээг чанд мөрдөн ажиллана.

## НАЙМ. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

8.1 Энэхүү гэрээг хоёр тал хянан баталгаажуулж, гарын үсэг зурсан өдрөөс эхлэн жилийн хугацаанд хүчин төгөлдөр болно.

8.2 Гэрээ нь хяналт шинжилгээний ажлын жилийн хугацаа дууссанаар дуусгавар болно.

## ЕС. БАЙГАЛЬ ОРЧИН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЧИГЛЭЛ ХАМРАХ ХҮРЭЭ

9.1 Байгаль орчны бохирдлын хяналт шинжилгээний ажлын хамрах хүрээ нь “Сэкер Ресорсус Монголиа” ХХК-ийн Хотгорын уурхайн эзэмшлийн талбайд хэрэгжихээр төлөвлөгдөнө.

9.2 Байгаль орчны бохирдлыг тодорхойлох объект нь “Сэкер Ресорсус Монголиа”-ХХК-ийн Хотгорын уурхайн эзэмшилд байх ба орчны бохирдлын хяналт шинжилгээний, сорьц (дээж)-ыг тухайн мэргэжилтний заасан цэгээс болон гүйцэтгэгч байгууллага орчны бохирдол ихтэй байна гэж үзвэл нэмэлтээр дээж авч болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| **ЗАХИАЛАГЧ:** | **ГҮЙЦЭТГЭГЧ:** |
|---|---|
| “СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА” ХХК-ийн үйл ажиллагаа хариуцсан захирал<br>__________ М.БАЯРМАНЛА | Байгаль орчин шинжилгээний лабораторийн эрхлэгч<br>__________ А.ЖАВЗАННАМЖИЛ |
| Байгаль орчин хариуцсан ажилтан<br>__________ Б.ДЭЛГЭРЭХ | |
| **Хаяг:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 15-р хороо, Махатма Гандигийн гудамж Корпорейт Хотел энд Конвейшн Центр, 6 давхар | **Хаяг:** Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Номгон , УЦУОШТӨВ |
| **Утас:** 11330828, 80300066 | **Утас:** ....88059319.......... |

# ОРЧНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС, ҮНЭ ТАРИФ

## 1.Агаарын чанарын хяналт шинжилгээ:

| № | Тодорхойлох үзүүлэлт | Сорьц авах давталтын тоо | Шинжилгээ хийх цэгийн тоо | Нэгж шинжилгээний үнэ (₮) | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хүхэрлэг хий ($SO_2$) | 2 | 2 | 9000 | 36000 |
| 2 | Азотын давхар исэл ($NO_2$) | 2 | 2 | 9500 | 38000 |
| 3 | Тоосонцор PM-10 | 2 | 2 | 20000 | 80000 |
| 4 | Нарийн ширхэгт тоос (PM-2.5) | 2 | 2 | 20000 | 80000 |
| Нийт үнэ (төгрөг)=234000 | | | | | |

## 2.Хөрсний чанарын хяналт шинжилгээ:

| № | Тодорхойлох үзүүлэлт | Сорьц авах давталтын тоо | Шинжилгээ хийх цэгийн тоо | Нэгж шинжилгээний үнэ (₮) | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | | | 3 | 4 |
| *Агро химийн үзүүлэлтүүд* | | | | | |
| 1 | Анхан шатны боловсруулалт хийх | 2 | 3 | 8000 | 48000 |
| 2 | Хөрсний орчин-PH | 2 | 3 | 3000 | 18000 |
| 3 | Чийг | 2 | 3 | 10500 | 63000 |
| 4 | Ялзмаг | 2 | 3 | 8500 | 51000 |
| 5 | Аммонийн азот-$NH_4$ | 2 | 3 | 8900 | 53400 |
| 6 | Нитратийн азот-$NO_3$ | 2 | 3 | 5500 | 33000 |
| 7 | Сульфатын ион-$SO_4$ | 2 | 3 | 6000 | 36000 |
| 8 | Эрдэс фосфор-$P_2O_5$ | 2 | 3 | 6500 | 39000 |
| Нийт үнэ (төгрөг)=341400 | | | | | |

## 3.Гадаргын усны хяналт шинжилгээ:

| д/д | Тодорхойлох үзүүлэлт | Шинжилгээ хийх арга | Цэгийн тоо | Нэгж шинжил-гээний үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| *Усны ерөнхий үзүүлэлтүүд* | | | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Усны орчин (PH) | Шууд хэмжлийн зөөврийн багажаар | 2 | 1500 | 3000 |
| 2 | Цахилгаан дамжуулах чанар (EC) | Шууд хэмжлийн багажаар | 2 | 1500 | 3000 |
| 3 | Булингаршил | | 2 | 1000 | 2000 |
| 4 | Жинлэгдэх бодис | Жингийн арга | 2 | 5000 | 10000 |
| 5 | Ууссан хүчилтөрөгч($O_2$ ) | Иодометрийн аргаар | 2 | 3500 | 7000 |
| 6 | Биохимийн хэрэгцээт хүчил төрөгч | Титрийн арга | 2 | 17000 | 34000 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Перманганатын исэлдэх чанар (ПИЧ) | Хүчиллэг орчинд тодорхойлох арга | 2 | 5500 | 11000 |
| 8 | Хатуулаг | Комплексонометрийн арга | 2 | 1500 | 3000 |
| 9 | Кальци ($Ca^{2+}$) | Комплексонометрийн арга | 2 | 1500 | 3000 |
| 10 | Магни ($Mg^{2+}$) | Тооцооны арга | 2 | 1000 | 2000 |
| 11 | Натри+Кали ($Na^{+}$+$K^{+}$) | Тооцооны арга | 2 | 1000 | 2000 |
| 12 | Гидрокарбонат ($NCO_3$) | Потенциометрийн арга | 2 | 2500 | 5000 |
| 13 | Хлорид ($CL^{-}$) | Аргентометрийн арга | 2 | 2500 | 5000 |
| 14 | Сульфат ($SO_4^{2-}$) | Турбидиметрийн арга | 2 | 3500 | 7000 |
| 15 | Эрдэсжилт | Тооцооны арга | 2 | 1500 | 3000 |
| 16 | Аммонийн азот ($NH_4$-N) | Несслерын арга | 2 | 3500 | 7000 |
| 17 | Нитритийн азот ($NO_2$-N) | Гриссийн арга | 2 | 3000 | 6000 |
| 18 | Нитратын азот ($NO_3$-N) | Салицилатын арга | 2 | 4000 | 8000 |
| 19 | Фосфат ($PO_4$-P) | Фотоколориметрийн арга | 2 | 2500 | 5000 |
| 20 | Төмөр (Fe) | Спектрофотометрийн арга | 2 | 2500 | 5000 |
| 21 | Фтор (F) | Фотоколориметрийн арга | 2 | 2500 | 5000 |
| Нийт үнэ (төгрөг)=136000 | | | | | |

БАТЛАВ
“ЦЭВЭР ХОТ” ОНӨААТҮГАЗРЫН
ЗАХИРАЛ Ц.БАЯСГАЛАН
..............................................
........оны.....сарын.......

БАТЛАВ
“СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА ХХК“
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
М.ЧОЙДОРЖ........................................
...... оны ..... сарын .....

# ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

№ .... 202302010021

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.**Гэрээний зорилго:** Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулж ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэн ажиллах талаар иргэн, байгууллага, аж ахуйн нэгжтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил гүйцэтгэх гэрээг байгуулах, хэрэгжүүлэх, дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү гэрээний эрх зүйн үндэслэл нь Иргэний тухай хуулийн 343-346, 350-353, 355, Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6.4 дэх зүйл заалтууд байна.

1.3.Энэхүү гэрээний хэрэгжилтэд тухайн байгууллагын удирдах ажилтнууд болон сумын Засаг дарга, ажлын алба, хөндлөнгийн хяналтын байгууллага, хууль журам гэрээгээр тохирсон хэм хэмжээнд хяналт тавина.

1.4.Их цэвэрлэгээ болон бусад хог хаягдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлээр сум болон төрийн байгуулага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллана.

## Хоёр.Гэрээ байгуулагч талууд

2.1. Гэрээг **нэг талаас** “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ыг төлөөлж цаашид “тээвэрлэгч гэх” орлогын байцаагч ажилтай М.Алимаа **нөгөө талаас** “Тээвэрлүүлэгч гэх” **“СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА ХХК”** төлөөлж Б.Дэлгэрэх нар харилцан тохиролцон энэхүү гэрээг байгуулав.

## Гурав. Тээвэрлэгчийн эрх үүрэг

3.1.Хог хаягдал тээвэрлэх чиглэл хуваарийг тогтоож Сумын Засаг даргаар батлуулж мөрдөн ажиллана.

3.2.Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхай, Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Зээгтийн нүүрсний уурхайн хог хаягдлыг тогтоосон хуваарийн дагуу зориулалтын тээврийн хэрэгслээр ачиж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт хүргэн дарж булшлах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

3.3.Уул уурхайн хортой, тусгай хог хаягдлыг холбогдох журмын дагуу тээвэрлэнэ.

3.4. Аж ахуйн нэгж, байгууллагуудын хог хаягдлыг уурхайгаас ачиж тээвэрлэнэ.

3.5.Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ үзүүлсэн төлбөрийг нэхэмжлэх, заасан хугацаанд төлөхийг шаардах эрхтэй \Зөрчлийн тухай хуулийн 7.6.4 дэхь заалт\

3.6.Ажил үйлчилгээний дагуу иргэдийн хог хаягдлын төлбөр тооцоо хийгдээгүй тохиолдолд хог хаягдлыг тээвэрлэхгүй ба түүнээс гарсан асуудлыг тус байгууллага хариуцахгүй.

3.7.Тухайн иргэн ахуй нэгжийн эзэн захирал ХХТХ-ийн 10.2.4-т заасны дагуу хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хийх эрх бүхий байгууллагад шилжүүлэх, ХХТХ-ийн 10.2.1-т заасны дагуу ангилан ялгах

3.8.Хог хаягдлыг зориулалтын битүүмжлэлтэй аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

## Дөрөв. Тээвэрлүүлэгчийн эрх, үүрэг

4.1 Хог тээврийн гэрээний төсөлтэй танилцаж, хог хаягдлын тухай хуулийн 10.2.3-т заасны дагуу гэрээ байгуулах

4.2.Гэрээний дагуу хог хаягдлаа сардаа дуудлагаар хуваарийн дагуу ачуулах

4.3 ХХТХ-ийн 10.2.2-т заасны дагуу хог хаягдлыг түр хадгалах савны стандартыг хангасан хогийн савтай байх /галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тундасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн/, ХХТХ-ийн 10.2.1-т заасны дагуу ангилан ялгах

4.4 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг ХХТХ-ийн 10.2.7-т заасны дагуу тогтоосон хугацаанд төлөх

4.5 Тухайн аж ахуйн нэгж, байгууллага, орчин тойрныхоо 50-100 метр хүртэлх зайг цэвэрлэж тээвэрлүүлэх.

4.6 Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох, хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх

4.7 Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаяхыг хориглоно

4.8 Нийтийн эдэлбэр газар, ногоон бүсэд хог хаяхыг хориглоно

4.9 Хог хаягдлыг ил задгай шатаахыг хориглоно

4.10 Хог хаягдлын үйлчилгээтэй холбоотой санал гомдлыг 7044-4200 утсаар мэдээллэнэ.

## Тав.Төлбөрийн нөхцөл

5.1 Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийг үндэслэн хог хаягдал гаргасны төлбөрийг \Баянхонгор сумын 2019.04.11 12\12 иргэдийн хурлын тогтоолоор батлагдсан төлбөрийн хэмжээгээр **уурхай нь аюултай хог хаягдал 45000₮-**ийг улирал тутам Төрийн сан дахь 100032000947 тоот дансанд буюу бэлнээр орлогын байцаагчид, тухайн баг хариуцсан жолоочид бэлэн мөнгөний баримтаар тушаана.

## Зургаа. Гэрээний хугацаа

6.1 Гэрээ нь 2023 оны 01 сарын 01-ны өдрөөс 2023 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

6.2 Гэрээний хугацаа дуусгавар болохоос ажлын 10 хоногийн өмнө тээвэрлүүлэгч талаас гэрээг сунгах хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг хүчингүйд тооцож хог тээвэрлэлтийг бүрэн зогсооно.

6.3 Холбогдох байгууллагууд үйл ажиллагаагаа бүр мөсөн зогсоосон нь нотлогдсон тохиолдолд уг гэрээг дуусгавар болсонд тооцно.

## Долоо. Талуудын хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

7.1 Талууд хагас бүтэн жилээр гэрээний биелэлтийг дүгнэж, цаашид илүү үр дүнтэй хамтран ажиллах боломжийг тодорхойж тооцоо нийлнэ.

7.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хог хаягдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

7.3 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

## Найм. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага

8.1 Гүйцэтгэгч компани нь захиалгат ажлыг гүйцэтгэхтэй холбоотой Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.

8.2 Захиалгат ажлыг гүйцэтгэхтэй холбоотой Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болзошгүй тохиолдолоос урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах, үйлдвэрлэлийн ослоос ажилтанд учирсан хохирлыг нөхөн төлөх, ажил гүйцэтгэх ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах асуудлыг гүйцэтгэгч компани хариуцан ажиллана.

## Ёс. Бусад

9.1 Гэрээ нь талууд батлаж, гарын үсэг зурж тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

9.2 Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.3 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд нэг хувийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөгөө хувийг нь тус байгууллага хадгална.

| ТЭЭВЭРЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ: | ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| ЦЭВЭР ХОТ ОНӨААТҮГ-Г ТӨЛӨӨЛЖ ОРЛОГЫН БАЙЦААГЧ: | “СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА ХХК” ТӨЛӨӨЛЖ БАЙГАЛЬ ОРЧИН ХАРИУЦСАН АЖИЛТАН |
| ................................ М.АЛИМАА | ................................................Б.ДЭЛГЭРЭХ |
| **Хаяг:** Номгон 1 дүгээр баг Дөвөнтийн заалны 2 дугаар давхарт | **Хаяг:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 15-р хороо, Махатма Гандигийн гудамж Корпорейт Хотел энд Конвейшн Центр, 6 давхар |
| | **Утас**: 11330828, 80300066 |

**SAKER RESOURCE MONGOLIA LLC**
**CONTRACT HANDOVER PAGE/**
**ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ХУУДАС**

Original to be kept by/Эхийг хадгалах: Legal Division/Хуулийн хэлтэс
Issue Date/Гаргасан огноо: 2023.06.05
Pages/Хуудас: 1

***Гэрээний товч утга:*** Энэхүү Гэрээгээр Гүйцэтгэгч нь захиалагчид гэрээний хавсралтад дурдсан бүтээгдэхүүнийг бэлтгэн Хотгор, Зээгтийн уурхайд байршуулах ажил байна.

***Нийт үнэ:*** 5,000,000 төгрөг (НӨАТ орсон дүн)

***Гэрээний хугацаа:*** 2023 оны 06 дүгээр сарын 07-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл

***Гэрээний байгуулах хүсэлтийг хариуцсан албан тушаалын тодорхойлолт, компанийн ажлын төлөвлөгөөнд заасны дагуу иргүүлсэн, цаашид гэрээний хэрэгжилтийг хариуцаж ажиллах ажилтан:***

Байгаль орчин хариуцсан ажилтан: ...Б. Дагсурэн...

***Гэрээний төслийг бэлтгэсэн:*** Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын стандарт гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар бэлтгэв.

Туслах хуульч: Б. Буянтогтох Б.Буянтогтох

The undersigned confirms that the draft contract has been reviewed and approved the final version of the contract. (Contract No. ............. /2023) 20230201 0020
Дор гарын үсэг зурсан нь 2023 оны ..................... дугаар Гэрээний төслийг хянаж, гэрээний эцсийн хувилбарыг зөвшөөрч байна.

| Contract title/Гэрээний нэр: | ЗАХИАЛГАТ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ (Жинст Цохио ХХК) | | | | |
|---|---|---|---|---|---|
| Renewed by /Хянасан: | Divisions/ Газар, хэлтэс | Name/Овог, нэр | Comment/Санал | Date/ Огноо | Sign/Гарын үсэг |
| Saker Resource Mongolia LLC | Гүйцэтгэх захирал | М.ЧОЙДОРЖ | | | [signature] |
| Saker Resource Mongolia LLC | Үйл ажиллагаа хариуцсан захирал | М.БАЯРМАНЛА | Нэмэлт саналгүй | 2023.06.07 | М.Б |
| Saker Resource Mongolia LLC | Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан менежер | Б.МӨРӨНГУА | (Өдөрт -14 ажлын 16') [illegible] | 2023/06/07 | Б.Мөрөнгуа |

N.B.: If the person is on the site or on a business trip then confirmation should be obtained via e-mail and should be attached to the confirmation page. In the case of absence of signatory due to illness or other private reasons the acting officer shall sign on the confirmation page.
After all approvals, contract could be approved by Executive Director.
Анхаарах нь: Хэрэв тухайн хүн орон нутаг дахь ажлын байранд, эсхүл томилолттой байгаа бол зөвшөөрлийг цахим шуудангаар авч хяналтын хуудаст хавсаргана. Гарын үсэг зурагч нь өвчний, эсхүл хувийн бусад шалтгаанаар эзгүй байгаа тохиолдолд үүргийг орлон гүйцэтгэж буй ажилтан хяналтын хуудаст гарын үсэг зурна. Бүх зөвшөөрлийг авсны дараа Гүйцэтгэх захирлаар гарын үсэг зуруулна.

**БАТЛАВ:**
"СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА"
ХХК-ийн

М.ЧОЙДОРЖ
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

**БАТЛАВ:**
"ЖИНСТ ЦОХИО" ХХК-ийн

Ж.ПҮРЭВСҮРЭН
ЗАХИРАЛ

**ЗАХИАЛГАТ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**
№

2023 оны 06 дугаар сарын ..08 Улаанбаатар хот

20230201002 0

Энэхүү ЗАХИАЛГАТ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ (цаашид "Гэрээ" гэх)-г

Нэг талаас: **"СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА" ХХК** (рд: 2862468) (цаашид "Захиалагч" гэх), түүнийг төлөөлж Үйл ажиллагаа хариуцсан захирал М.Баярманла,

Нөгөө талаас: **"ЖИНСТ ЦОХИО"** ХХК (рд: 3130002 ) (цаашид "Гүйцэтгэгч" гэх),түүнийг төлөөлж Менежер Ж.Дуламсүрэн,

нар (цаашид хамтад "Талууд" гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон дараах гэрээг харилцан тохиролцож байгуулав.

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээгээр нь Гүйцэтгэгч нь Захиалагчийн захиалгаар энэ Гэрээний Хавсралт №01-т заасан шаардлага бүхий Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутагт орших Зээгтийн нүүрсний уурхай болон Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хотгорын нүүрсний уурхайд байрлуулах гурав ангилан ялгах зориулалтын төмөр хогийн сав хийх ажлыг (цаашид "Захиалгат ажил" гэх) гүйцэтгэн хүлээлгэн өгөх, Захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан ажлын хөлсийг төлөх болон талуудын хооронд үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино.

## ХОЁР. ЗАХИАЛГАТ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

2.1. Гүйцэтгэгч нь Захиалгат ажлыг энэхүү Гэрээг байгуулсан өдрөөс эхлэн 14 хоног (ажлын арав хоног буюу 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн мөн оны 6 дугаар сарын 22-ны өдрийг дуусталх хугацаанд)-т багтаан хийж гүйцэтгэж хоёр уурхайн кемпэд хүргэж, байршуулсан байна.

2.2. Гэрээний 2 дугээр зүйлийн 2.1-д заасан хугацааг хуанлийн хоногоор тооцно.

2.3. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгаж болно.

## ГУРАВ. АЖЛЫН ХӨЛС

3.1. Захиалгат ажлын хөлс нь 5,000,000 (Таван сая) төгрөг байна. Энэ үнэд материал, ажлын хөлс, тээврийн зардал, НӨАТ болон бусад татвар хураамж багтсан дүн болно.

3.2. Захиалагч нь ажлын хөлсийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн энэхүү Гэрээнд заасан журмын дагуу Гүйцэтгэгчийн нэрлэсэн харилцах ХААН банкны 5249123604 тоот дансанд төлбөрийн нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ.



*Захиалагч* ____________________ *Гүйцэтгэгч* ____________________

3.3. Захиалагч нь Захиалгат ажлын төлбөрийг дараах журмаар төлнө.Үүнд:

3.3.1. Захиалагч нь ажлын хөлсний 80 хувь буюу 4.000.000 (Дөрвөн сая) төгрөгийг гэрээ байгуулснаас хойш ажлын 2 хоногт багтаан Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн түүний дансанд шилжүүлнэ.

3.3.2. Гүйцэтгэгч нь Захиалгат ажлыг 100% гүйцэтгэж дууссан буюу энэ Гэрээний 4.2-т заасны дагуу ажил хүлээлцэх актаар хүлээлгэн өгсний дараа Захиалагч ажлын 2 хоногт багтаан ажлын хөлсний үлдэгдэл (20) хувь буюу 1.000.000 (Нэг сая) төгрөгийг Гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ.

3.4. Гэрээгээр тохиролцсон төлбөрийг Гүйцэтгэгчийн харилцах данс руу Захиалагч шилжүүлсэн өдрөөр төлбөрийг төлсөнд тооцно. Банкны үйл ажиллагаанаас шалтгаалж саатсан төлбөрийн хариуцлагыг Захиалагч хүлээхгүй.

3.5. Гэрээний хэрэгжилтийн хугацаанд Талууд Гэрээний 2 дугаар зүйлийн 2.2-т заасан ажил гүйцэтгэх хөлс, зардлын хэмжээг өөрчлөхгүй байхаар тохиролцов. Гэрээнд заасан ажлын чанарыг сайжруулах, ажлын үр дүнг энэхүү Гэрээнд заасан хугацааны дотор хүлээлгэн өгөх талаар яаралтай арга хэмжээг авахыг Захиалагч шаардсан тохиолдолд Гүйцэтгэгч тухайн шаардлагыг биелүүлэхтэй холбогдуулан ямар нэгэн нэмэлт төлбөр шаардахгүй.

## ДӨРӨВ. АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ

4.1. Гүйцэтгэгч нь Захиалгат ажлыг гүйцэтгэж дуусмагц, Захиалагчид мэдэгдэн Захиалгыг ажлыг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хотгорын нүүрсний уурхай болон Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутагт орших Зээгтийн нүүрсний уурхай руу тээвэрлэн, зөөж байрлуулна.

4.2. Захиалагч нь Захиалгат ажлыг шалган ажил хүлээлцэх актаар хүлээн авна. Уг акт нь гэрээний салшгүй хэсэг болно.

## ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

*5.1. Захиалагч талын эрх, үүрэг:*

5.1.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;
5.1.2. Захиалагч нь захиалгат ажил үйлчилгээний явц, үр дүнг шалгах;
5.1.3. Захиалагч нь гүйцэтгэгч талд захиалж байгаа бүтээгдэхүүний тоо, хэмжээ, загварыг гаргаж өгөх;
5.1.4. Захиалагч нь гүйцэтгэгч талд ажлын тоо, хэмжээ, загварыг буруу өгснөөс гарах үр дагаврыг хариуцах;
5.1.5. Захиалагч нь Ажлын гүйцэтгэлийг шалгах бөгөөд чанаргүй хийсэн, дутуу хийсэн ажлыг гүйцээн хийхийг шаардах;
5.1.6. Гүйцэтгэгчид гэрээгээр тохиролцсон үнэ хөлсийг төлөх;
5.1.7. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг хугацаанд нь хүлээн авах;
5.1.8. Гүйцэтгэгчид энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхэд нь шаардагдах бүхий л мэдээ, мэдээлэл, зааварчилгааг өгөх;
5.1.9. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

*5.2. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг:*

5.2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Захиалагчаас шаардах;
5.2.2. Гүйцэтгэгч нь гэрээний төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөхийг шаардах;
5.2.3. Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан нэмэлт мэдээлэл авах, захиалга өөрчлөгдсөн тохиолдолд шаардлагатай гэж үзвэл хугацаа сунгахыг хүсэх;
5.2.4. Гүйцэтгэгч нь Захиалгат ажлыг чанар, норм, стандартын шаардлагын дагуу хийж гүйцэтгэх;



*Захиалагч* ________________ *Гүйцэтгэгч* ________________

5.2.5. Ажлын явцад болон дараа илэрсэн зөрчил, чанарын доголдлыг тухай бүр өөрийн хөрөнгөөр арилгах, нөхөн гүйцэтгэх;
5.2.6. Гэрээний 2.1-д заасан хугацааг чанд баримтлах;
5.2.7. Захиалагчийн өгсөн заавар, зөвлөмжийг анхааран ажиллах;
5.2.8. Захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүн шилжүүлэх, шилжүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг хариуцах;
5.2.9. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

## ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Гүйцэтгэгч нь Захиалгат ажлыг Гэрээгээр тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэн Захиалагч талд шилжүүлээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, эсхүл захиалгат ажлаа биелүүлэх боломжгүй гэдэг нь нэгэнт тодорхой болсон тохиолдолд Захиалагчийн санаачилгаар Гэрээг цуцална.

6.2. Гэрээний 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу Гэрээг цуцалснаар Гүйцэтгэгч нь Захиалагчийн төлсөн төлбөрийг бүрэн буцаан төлөх хариуцлага хүлээнэ.

6.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учирсан шууд хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

6.4. Аль нэг тал нь энэ Гэрээнд заасан үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5%-тай тэнцэх алдангийг нөгөө талдаа төлнө.

## ДОЛОО. МЭДЭГДЭЛ

7.1. Захиалагч дор дурдсан этгээдийг энэхүү Гэрээний ерөнхий зохицуулалтыг хариуцах төлөөлөгчөөр томилсон болно.Үүнд:

7.1.1. Ажилтны овог, нэр:Б.Дэлгэрэх
7.1.2. Албан тушаал: Байгаль орчин хариуцсан ажилтан
7.1.3. Цахим хаяг: delgerekh@srmongolia.mn
7.1.4. Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, Корпорэйт хотел энд Конвейшн центр, 6 давхар,
7.1.5. Харилцах утас:11330828, 80300066;

7.2. Гүйцэтгэгч дор дурдсан этгээд хариуцна дор дурдсан этгээдийг энэхүү Гэрээний ерөнхий зохицуулалтыг хариуцах төлөөлөгчөөр томилсон болно.Үүнд:

7.2.1. Ажилтны овог, нэр: Ж.Дуламсүрэн
7.2.2. Албан тушаал: Менежер
7.2.3. Цахим хаяг: J.Dulamsuren@gmail.com
7.2.4. Хаяг: Баянхонгор Номгон 1-р баг 89-3 тоот
7.2.5. Харилцах утас: 99711000

7.3. Мэдэгдэл нь тал тус бүрийн дээрх хаягууд руу бичгийн хэлбэрээр хүргэгдэнэ. Аль нэг талд хаяглан биечлэн эсвэл факсаар хүргэгдсэн аливаа мэдэгдлийг хүлээн авсан эсвэл өгсөн нь тухайн хүргэгдэн ирсэн өдрөөр хүргэгдсэнд тооцогдох ба, хэрэв тухайн өдөр нь ажлын бус өдөр тохиосон бол дараагийн ажлын өдөр гэж тооцно. Цахим шуудангаар явуулсан аливаа мэдэгдэл нь цахим шууданг хүлээн авсан тухайгаа эргээд мэдэгдээгүй бол явуулсан өдрөөс ажлын гурав дахь өдөр өгсөн эсвэл хүлээн авсанд тооцогдоно.

7.4. Аливаа мэдэгдэл, мэдээ буюу энэхүү гэрээний дагуу илгээгдэх нэхэмжлэх ба төлбөр төлөлт зэргийг бичгээр, Монгол хэл дээр боловсруулсан байх ба хэрэв биечлэн, факсаар, и-мэйлээр эсвэл шуудангаар хүргэгдсэн бол аливаа мэдэгдэл хүргэгдсэнд тооцно.



*Захиалагч* ________________ *Гүйцэтгэгч* [signature]

## НАЙМ. ГЭНЭТИЙН БА ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

8.1. Гэнэтийн ба Давагдашгүй хүчин зүйл гэж нэрвэгдэгч талын санаатай, хайхрамжгүй, эсхүл буруутай үйлдэл, эс үйлдлээс болоогүй, түүнийг урьдчилан мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан ба өөрийн бүх боломжоор түүнийг даван туулах, эсхүл зайлуулах буюу үр дагаврыг нь бууруулах арга хэмжээ авсан, Гэрээний үүргээ гүйцэтгэх боломжгүйд шууд хүргэсэн нөхцөл байдлыг хэлнэ. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлд зөвхөн дараах нөхцөл байдал хамаарна:

8.1.1. Дайн, зэвсэглэсэн бослого, бослого, гадны түрэмгийлэл, дайралт, хувьсгал, нийтээрээ хориглох, оршин суугчдын эсэргүүцэл, иргэний болон төрийн бус байгууллагын эсэргүүцэл;

8.1.2. Байгалийн гамшиг тухайлбал, ноцтой нөлөөлөх шуурга, хар салхи, ноцтой нөлөөлөх газар хөдлөлт, үер, аюултай хэмжээтэй цас, гал эсхүл аянгаас үүдсэн сүйрэл;

8.1.3. Дэлбэрэлт, терроризмийн үйлдэл;

8.1.4. Нийтийг хамарсан тахал, өвчнөөс шалтгаалж хорио цээрийн дэглэм албан ёсоор тогтоох;

8.1.5. Нийтийг хамарсан ажил хаялт тухайн хуулийн этгээдэд өрнөх;

8.1.6. Захиргааны хууль ёсны болон хууль бус хориглосон шийдвэр, эд хөрөнгө хураах, албадан авах, бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нийгэмчлэх, холбогдох хуульд өөрчлөлт оруулсан нь үүргийн гүйцэтгэлд ноцтой нөлөөлсөн, тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрлийг хууль бусаар цуцалсан, тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрөл сунгахаас хууль бусаар татгалзсан, эсхүл олгохоос татгалзсан.

8.2. Нэрвэгдсэн тал нь гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлын талаар 3 (гурав) хоногийн дотор нөгөө талдаа мэдэгдэнэ.

8.3. Хэрэв нөгөө тал нь гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн талаарх мэдэгдлийг хүлээн зөвшөөрсөн бол нэрвэгдсэн тал нь давагдашгүй хүчин зүйлээс үүдэн үүргээ гүйцэтгээгүйн хариуцлагаас чөлөөлөгдөж, тухайн үүргийн гүйцэтгэл нь гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйл арилтал эсхүл цуцлагдах хүртэл хойшлогдоно.

8.4. Нэрвэгдсэн талын хүсэлтээр, нөгөө тал нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн улмаас учирсан зардлыг талууд тус бүр өөрсдөө хариуцаж төлнө.

8.5. Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйл 30 (гуч) хоногоос илүү хугацаагаар үргэлжилсэн эсвэл ийнхүү үргэлжлэх нь гарцаагүй гэж Талууд үзсэн нөхцөлд Талууд харилцан тохиролцож Гэрээний нөхцөлийг өөрчлөх эсвэл Гэрээг цуцалж болно. Хэрэв Гэрээ цуцлагдсан бол аль ч тал цуцалснаас үүдэх хохирлыг нэхэмжлэхгүй ба Захиалагч зөвхөн тухайн гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйл эхэлсэн өдөр хүртэлх зохих ёсоор хийж гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөх бөгөөд гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авна.

## ЕС. БУСАД ЗҮЙЛ

9.1. Энэхүү Гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, Захиалагчийн төлөөлөгч тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.



*Захиалагч* ________________ *Гүйцэтгэгч* ________________

9.2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд талууд харилцан тохиролцож бичгээр үйлдэн, эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болох ба энэхүү Гэрээний нэмэлт өөрчлөлт нь Гэрээний салшгүй хэсэг байна.

9.3. Гэрээ хүчин төгөлдөр болсноор энэхүү Гэрээ нь талууд хоорондын бүхий л ойлголт ба тохиролцоог төлөөлөх ба талууд хоорондын өмнөх бүх бичгэн эсвэл аман гэрээ хэлцэл, тохиролцоо, амлалт, захидал харилцаа, төлөөлөл ба ойлголтыг орлоно гэдгийг талууд хүлээн зөвшөөрөв.

9.4. Гэрээний хавсралт нь энэхүү Гэрээний салшгүй нэг хэсэг болох бөгөөд Гэрээний нэгэн адил хүчинтэй байна.

9.5. Энэхүү Гэрээтэй холбоотой аливаа маргааныг Талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ. Эвийн журмаар гуч (30) хоногийн дотор шийдвэрлэгдэх боломжгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

9.6. Талууд Гэрээг 2 эх хувь үйлдэж тус бүр нэг хувийг хадгалах ба хууль зүйн адил хүчинтэй байна.

**АРАВ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ**

10.1 Гүйцэтгэгч компани нь захиалгат ажлыг гүйцэтгэхтэй холбоотой Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.

10.2 Захиалгат ажлыг гүйцэтгэхтэй холбоотой Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болзошгүй тохиолдолоос урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах, үйлдвэрлэлийн ослоос ажилтанд учирсан хохирлыг нөхөн төлөх, ажил гүйцэтгэх ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах асуудлыг гүйцэтгэгч компани хариуцан ажиллана.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛАГЧ:**
"СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА" ХХК-ийг төлөөлж,

М.БАЯРМАНЛА
ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Б.ДЭЛГЭРӨХ
БАЙГАЛЬ ОРЧИН ХАРИУЦСАН АЖИЛТАН

**ГҮЙЦЭТГЭГЧ:**
"ЖИНСТ ЦОХИО" ХХК-ИЙГ төлөөлж,

Ж.ДУЛАМСҮРЭН
МЕНЕЖЕР

**Хаяг:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 15-р хороо, Махатма Гандигийн гудамж Корпорейт Хотел энд Конвейшн Центр, 6 давхар

**Утас:** 11330828, 80300066

**Хаяг:** Баянхонгор аймаг Баянхонгор сум Номгон баг 1-89-3 тоот

**Утас: 88116022, 99711000**



*Захиалагч* ________________

*Гүйцэтгэгч* ________________

## АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны 05 дугаар сарын ... Улаанбаатар хот

**Нэг. Захиалгат ажилд тавигдах шаардлага:**

1.1. Хогийн сав нь дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

1.1.1. хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;

1.1.2. галд тэсвэртэй материалаар хийгдсэн;

1.1.3. хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.

1.2. Захиалгын хогийн сав нь дараах хийц, хэлбэр, өнгө, тэмдэглэгээ, зориулалтай байна.Үүнд:




**Хоёр. Захиалгат ажлын техникийн даалгавар:**

| № | Бүтээгдэхүүн | Хэмжих нэгж | Хэмжээ | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | 3 ангилдаг төмөр хогийн сав | м | Урт-2<br>Өргөн-1<br>Өндөр-1,4 | 3ш хаалгатай |

**Гурав. Нийт хийлгэх захиалгын ажил:**

| № | Бүтээгдэхүүн | Нэгж | Тоо | Нэгжийн үнэ (төгрөг) | Нийт үнэ (төгрөг) | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|



*Захиалагч* ___________________ *Гүйцэтгэгч* [signature]

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | 3 ангилдаг төмөр хогийн сав | ш | 2 | 2,500,000₮ | 5,000,000₮ | ............. |

## АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АКТ

2023 оны 06 дугаар сарын ... Улаанбаатар хот

**Нэг.Хүлээлцэх ажил**

1.1. Захиалагч "СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА" ХХК-д Гүйцэтгэгч "ЖИНСТ ЦОХИО" ХХК нь Захиалгат ажлын үр дүн болох гурав ангилан ялгах зориулалтын төмөр хогийн савыг Говь-Алтай аймгийн Чандмань сумын Зээгтийн нүүрсний уурхай, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайн тус бүрийн хог хаях хяналтын цэгт байрлуулан хүлээлгэж өгөв.

**Хоёр.Хүлээлцсэн зүйлс:**

| № | Хүлээлцсэн зүйлийн нэр | Тоо ширхэг | Байрлуулах газар |
|---|---|---|---|
| 1. | 3 ангилан ялгадаг зориулалтын төмөр хогийн сав | 1 | Говь-Алтай аймгийн Чандмань сумын Зээгтийн нүүрсний уурхайн хог хаях хяналтын цэгт |
| 2. | 3 ангилан ялгадаг зориулалтын төмөр хогийн сав | 1 | Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Хотгорын нүүрсний уурхайн хог хаях хяналтын цэгт |

**ХҮЛЭЭН АВСАН:**

Захиалагчийг төлөөлж

“СЭКЕР РЕСОРСУС МОНГОЛИА” ХХК-ийн

..........................................................

Б.ДЭЛГЭРЭХ
БАЙГАЛЬ ОРЧИН ХАРИУЦСАН АЖИЛТАН

**ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:**

Гүйцэтгэгчийг төлөөлж

“ЖИНСТ ЦОХИО” ХХК-ийн

..................................................

Ж.ДУЛАМСҮРЭН
МЕНЕЖЕР